



**“ТАВАН ТОЛГОЙ ТҮЛШ” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/131

Улаанбаатар хот

**“Шахмал түлш тээвэрлэх болон хадгалах горим”
батлах тухай**

“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шахмал түлш тээвэрлэх болон хадгалах горим”-ыг хавсралтаар баталсугай.
2. Горимыг дагаж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Хууль эрх зүй, аудитын алба /Л.Батбаяр/, Борлуулалтын хэлтэс /Д.Миняа/ нарт үүрэг болгосугай.
3. Горимын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын алба /Р.Гансүх/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.ГАНБААТАР



Хавсралт

БАТЛАВ: ГҮЙЦӨТГЭХ ЗАХИРАЛ
М.ГАНБААТАР

ШАХМАЛ ТҮЛШИЙГ ТЭЭВЭРЛЭХ БОЛОН ХАДГАЛАХ ГОРИМ

2020 оны 04-р сарын 05 ны өдөр

Улаанбаатар хот

Ерөнхий зүйл

Сайжруулсан шахмал түлшийг цаашид "түлш" гэх тээвэрлэх хадгалахад энэхүү горимыг дагаж мөрдөнө.

1. АЧИЛТ БУУЛГАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ:

- 1.1. Шуудайтай түлшний ачилт ба буулгалт хураалтын үед ачаа өргөх зөөх ажлын стандартыг дагаж мөрдөнө. Үүнд: MNS-4970 -2000 он Хөдөлмөрийн Аюулгүй Ажиллагаа Эрүүл Ахуй "Өргөж зөөх ачааны массын дээд хэмжээ" стандартын-3.3 баримтлана.
- 1.2. Сэрээт өргөгчийн тусламжтайгаар автомашины тэвшин дээр байрлуулах ажлын явцад сэрээт ачигчийн ачаа өргөн тээвэрлэх стандартыг дагаж мөрдөнө. Үүнд: Хууль зүй, дотоод хэргийн Яамны 2007 оны дугаар 2744, Улсын Мэргэжлийн хяналтын газрын дугаар 7/1000 шийдвэрээр ЦАХИЛГААН СТАНЦ ДУЛААНЫ ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ДУЛААН- МЕХАНИКИЙН ТОНОГЛОЛЫН АШИГЛАЛТЫН ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ДҮРМИЙН 2.4.1 ; 2.4.4 ; 2.4.21 заалтуудыг баримтлана.
- 1.3. Автомашины тэвшин дээр 8 үеэс олонгүй давхарлан автомашины тэвшний урд хэсгээс эмх цэгцтэй хөөж хурааж, буулгахдаа мөн адил нэг захаас нь хөөж буулгана.
- 1.4. Түлшийг хавтгай зөөлөн татлагаар татаж тээвэрлэнэ.
- 1.5. Түлшний татлагыг хэт их чангалж түлшийг бутлахаас сэргийлнэ.
- 1.6. Түлш тээвэрлэх автомашин нь Монгол Улсын Замын хөдөлгөөний тухай хууль дүрэмд нийцсэн өндөрлөгөөтэй байна.
- 1.7. Тээвэрлэлтийн үед механикжсан тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэх хууль, дүрэм журмыг мөрдлөгө болгож ажиллана.

2. ХАДГАЛАЛТ:

- 2.1. Бүтээгдэхүүний сав баглаа боодол нь агаар чөлөөтэй нэвтрүүлдэг байна.
- 2.2. Шахмал түлш хадгалах агуулах нь дараах шаардлага стандартыг хангасан байна.
 - 2.2.1. Бороо ус чийгнээс хамгаалагдсан байна.
 - 2.2.2. Агааржуулалт болон агаар сэлгэдэг байна.
 - 2.2.3. Ажил гүйцэтгэх шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй байна.
 - 2.2.4. Галын дохиололтой байна.
 - 2.2.5. Галын хортой, тоо хэмжээ болон чанарын шаардлага хангасан байна.
 - 2.2.6. Орчны чийг хэмжих ажлын шаардлага хангасан багажтай байна.
 - 2.2.7. Орчны температур хэмжих ажлын шаардлага хангасан багажтай байна.
 - 2.2.8. Агуулах нь ашигтай талбай болон багана тулгуур, хана туурга, дээвэр хаалга үүд зэрэг нь бат бөх чанарын шаардлагад нийцсэн аюулгүй ажиллагааг хангасан байна.
- 2.3. Агуулахад хадгалах шахмал түлшийг модон болон пластик материалаар хийгдсэн поддон дээр хураана.
- 2.4. Поддон нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 2.4.1. 1м^2 талбайд 10кН даралтын хүчинд тэсвэртэй модон болон пластик байна.
 - 2.4.2. 1.5м^2 талбайд 15кН даралтын хүчинд тэсвэртэй модон поддон байна.
 - 2.4.3. $1200\text{мм} \times 800\text{мм}$ буюу 1.2м^2 талбаатай 160мм өндөртэй ЕВРО-Н1маркийн 5000кг масс буюу 50кН даалтын хүчинд тэсвэртэй (-40°C - $+70^{\circ}\text{C}$) зэрэг олон төрлийн сонголттой байна.
- 2.5. Зориулалтын поддон тавцан дээр агаар салхи сэлгэх, ус чийгнээс хамгаалж 25кг шахмал түлшийг 12-16 давхраас илүүгүй давхарлаж эмх цэгцтэй хураана.
- 2.6. Түлшийг хураахдаа агуулахын хананаас 60 см зайтай, хоёр эгнээ тутамд нэг хүн явах зүй үлдээж эмх цэгцтэй хураавал зохино.
- 2.7. Түлш хадгалах агуулахын зам талбай болон хаалга үүд нь автомашины орох гарах болон хөдөлгөөнд саад учруулахгүй байвал зохино.

3. ХАРУУЛ ХАМГААЛАЛТ:

- 3.1. Түлшний агуулах нь 24 цагийн харуул хамгаалалттай, харуул нь хяналтын тайлан мэдээг тогтмол хөтөлдөг журналтай байна.
- 3.2. Харуул нь мэдээ тайлангаа тогтоосон хугацаанд борлуулалтын албаны холбогдох нэр бүхий албан тушаалтанд мэдээлж байх үүрэгтэй.
- 3.3. Хяналтын камертай байвал зохино.
- 3.4. Агуулахад хураах шахмал түлшний тоо хэмжээг болон бүрэн бүтэн байдлыг агуулах хариуцсан нярав нь нарийн шалгаж хүлээн авна.
- 3.5. Шаардлагатай тохиолдолд агуулахад хадаглагдаж байгаа түлшнээс түүвэр дээж авч хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэнэ.

- 3.6. Түлшний чанар хариуцсан технологич нь лабораторийн шинжилгээний дүгнэлтийг цаг тухай бүрт нь холбогдох хүмүүст танилцуулж мэдээлэх үүрэгтэй.
- 3.7. Эд хариуцагч нь: Цаг агаарын болон гэнэтийн үзэгдэл, газар-хөдлөлт, гал-түймэр, салхи-шуурга, үер-ус мөн хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж сөрөг нөлөө үүсвэл холбогдох албан тушаалтанд цаг алдалгүй үнэн зөвөөр мэдэгдэж засварлаж хэвийн нөхцлийг хангуулах үүрэгтэй.